



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

239

2007 оны 4 дугаар сарын 27 ны өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот


Тогтоол хэрэгжүүлэх тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2001 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 05 тоот тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. "Нүдний шилний үйлдвэр" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын нийт хөрөнгийг ажиллагсдын хамт " Уламжлалт эм эмийн ургамлын компани" нийслэлийн өмчит үйлдвэрийн газарт нэгтгэн зохион байгуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй баталсугай. Үүнд:

- | | | |
|-----------------|----------------|---|
| Комиссын дарга: | Ж.Эрдэнэбаатар | -Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Төлөөллийн хэлтсийн дарга |
| Гишүүд: | А.Элбэгсайхан | -Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Төлөөллийн хэлтсийн мэргэжилтэн |
| | Ж.Бямбасүрэн | -Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Бүртгэл, хяналтын хэтсийн мэргэжилтэн |
| | С.Солонго | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн |
| | Ж.Энхбаяр | -Нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн |

Хоёр. Өмч хөрөнгө хүлээлцсэн акт, "Нүдний шилний үйлдвэр" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгасан болон холбогдох бусад материалыг 5 дугаар сарын 7-ны дотор бэлэн болгож танилцуулахыг Комиссын дарга /Ж.Эрдэнэбаатар /-д даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ


М.ЭНХБОЛД